



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/133/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Атарцэцэг
Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn
Аудитор: Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02.21 № 55

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.3, 16.5.4, 16.5.7, 41.2.2, 6.4.8, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлын төсвөөс 7,999.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн,
- Жилийн эцэст үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн боловч тооллогын материал дутуу, тооцоо бодоогүй,

8225020140

- Батлагдсан орон тоонд байхгүй голомтын эмчийг сумд ажиллуулан 4,468.4 мянган төгрөгийн хавсран ажилласны нэмэгдлийг үндэслэлгүйгээр олгосон,
- Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 106.7 мянган төгрөгийг илүү олгосон,
- Ажилтанд ажил хавсран ажилласны нэмэгдэл 360.0 мянган төгрөгийг шийдвэргүйгээр олгосон,
- Санхүүгийн тайланд нэгээс дээш жилийн насжилттай 30,473.5 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлагын үлдэгдэлтэй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус төв нь 2024 онд тарваган тахлын сэжигтэй дуудлага, хачигт халдвар, боом, шувууны томуу зэрэг өвчний гүнзгийрэл болон тандалт судалгаа шинжилгээг хийж ажилласан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 18,830.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 319,185.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй авч, 4,377,800.0 мянган төгрөгийн эмнэлгийн барилгыг хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 268,637.7 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд сургалт, зөвлөгөөн, бусад ажлаар Улаанбаатар хотод ажиллахад албан томилолт, шатахууны зардалд нийт 8,916.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвийн захирагчийн 4 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 55 арга хэмжээ бүрэн, 1 арга хэмжээ биелэгдээгүй, нийт дүнгээр 90.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн боловч дээд шатны байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П. ГҮНЖИДМАА

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	223,750,266.24	580,133,611.84
33	АВЛАГА	31,118,804.74	48,007,655.74
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	16,888,851.00
33500	Бусад авлага	31,118,804.74	31,118,804.74
33510	Байгууллагаас авах авлага	645,344.57	645,344.57
33520	Хувь хүмүүсээс авах авлага	30,473,460.17	30,473,460.17
35	БАРАА МАТЕРИАЛ	192,631,461.50	532,125,956.10
35100	Түүхий эд материал	132,309,676.50	454,489,559.40
35130	Эм боох материал	132,309,676.50	454,489,559.40
35400	Хангамжийн материал	60,321,785.00	77,636,396.70
35410	Бичиг хэргийн материал	3,404,150.00	3,729,700.00
35420	Аж ахуйн материал	19,295,913.00	22,537,958.70
35430	Сэлбэг хэрэгсэл	7,653,000.00	9,324,000.00
35440	Түлш, шатах тослох материал	12,483,879.00	12,725,879.00
35450	Барилгын засварын материал	1,529,900.00	2,106,400.00
35470	Бусад хангамжийн материал	15,954,943.00	27,212,459.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	387,070,510.73	4,911,326,146.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	387,070,510.73	4,911,326,146.24
39200	Биет хөрөнгө	273,590,510.73	4,797,846,146.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	33,592,500.00	4,411,392,478.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,946,336.32)	(118,987,106.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,684,000.00	76,684,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(49,814,847.16)	(60,234,347.20)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	352,337,319.38	673,389,364.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	(128,785,006.45)	(192,332,595.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,504,595.20	38,575,694.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,178,024.32)	(30,641,342.39)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,036,037.00	3,036,037.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,839,726.60)	(3,036,037.00)
39300	Биет бус хөрөнгө	113,480,000.00	113,480,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	113,480,000.00	113,480,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	610,820,776.97	5,491,459,758.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,003,025.50	25,335,165.18
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,003,025.50	25,335,165.18
41300	Өглөг	2,003,025.50	25,335,165.18
41360	Бусад өглөг	2,003,025.50	25,335,165.18
41361	Байгууллагад төлөх өглөг	2,003,025.50	8,346,314.18
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	16,988,851.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	608,817,751.47	5,466,124,592.90
51	Засгийн газрын хувь оролцоо	608,817,751.47	5,466,124,592.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	281,217,975.40	281,217,975.40
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	281,217,975.40	281,217,975.40
51200	Хуримтлагдсан үр дүн	295,166,916.57	5,152,473,758.00
51210	Өмнөх үеийн үр дүн	115,175,508.56	295,166,916.57
51220	Тайлант үеийн үр дүн	179,991,408.01	4,857,306,841.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,432,859.50	32,432,859.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	610,820,776.97	5,491,459,758.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	735,504,545.70	5,802,006,494.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	215,954,295.70	5,027,734,139.18
120	Нийтлэг татварын бус орлого	215,954,295.70	5,027,734,139.18
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	194,519,578.10	4,701,473,868.78
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	21,434,717.60	326,260,270.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	519,550,250.00	774,272,355.39
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	504,574,800.00	772,552,355.39
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	504,574,800.00	772,552,355.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,975,450.00	1,720,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,975,450.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,720,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	555,513,137.69	944,620,406.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	555,513,137.69	944,620,406.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,343,947.58	942,900,406.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,245,363.25	572,347,463.06
210101	Үндсэн цалин	239,733,056.71	375,100,346.72
210102	Нэмэгдэл	80,863,090.95	134,513,232.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,229,258.90	20,108,000.00
210104	Урамшуулал	27,409,004.74	42,625,884.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,512,822.65	72,044,412.73
210201	Тэтгэврийн даатгал	27,289,424.35	49,480,401.64
210202	Тэтгэмжийн даатгал	3,822,199.76	5,275,047.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,879,999.69	5,378,818.45
210204	Ажилгүйдлийн даатгал	775,399.61	2,666,897.51
210205	Эрүүл мэндийн даатгал	7,745,799.24	9,243,247.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,121,505.23	50,980,657.48
210301	Гэрэл, цахилгаан	2,335,571.55	2,723,128.49
210302	Түлш, халаалт	8,670,030.68	47,075,126.99
210303	Цэвэр, бохир ус	115,903.00	1,182,402.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,579,589.00	22,566,873.00
210401	Бичиг хэрэг	1,648,900.00	1,265,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,146,881.81	17,350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,577,347.19	1,605,273.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,189,000.00	2,345,700.00
210408	Бараа материал акталсны зардал	5,967,460.00	-
2105	Нормативт зардал	12,103,017.60	11,471,822.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,178,017.60	11,471,822.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	925,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	264,500.00	300,000.00
210604	Урсгал засвар	264,500.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,955,450.00	15,134,450.00
210702	Дотоод албан томилолт	9,955,450.00	15,134,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,903,492.00	2,085,741.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,866,992.00	1,267,741.00
210803	Даатгалын үйлчилгээ	442,600.00	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.00	335,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210807	Газрын төлбөр	49,400.00	-

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	398,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,658,207.85	195,968,987.11
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	65,658,207.85	195,968,987.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,169,190.11	1,720,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,169,190.11	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,707,646.11	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,461,544.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,720,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,720,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	179,991,408.01	4,857,386,087.59
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	79,246.16
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	79,246.16
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	179,991,408.01	4,857,306,841.43

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	519,550,250.00	757,383,504.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	519,550,250.00	757,383,504.39
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	504,574,800.00	755,663,504.39
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	504,574,800.00	755,663,504.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,975,450.00	1,720,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,975,450.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,720,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	519,550,250.00	738,553,504.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	519,550,250.00	738,553,504.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	495,381,059.89	719,944,653.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,504,112.50	538,327,229.66
210101	Үндсэн цалин	256,991,805.96	344,626,886.55
210102	Нэмэгдэл	80,863,090.95	130,966,458.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,229,258.90	20,108,000.00
210104	Урамшуулал	27,409,004.74	42,625,884.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,521,822.65	72,044,412.73
210201	Тэтгэврийн даатгал	27,289,424.35	49,480,401.64
210202	Тэтгэмжийн даатгал	3,822,199.76	5,275,047.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,879,999.69	5,378,818.45
210204	Ажилгүйдлийн даатгал	775,399.61	2,666,897.51
210205	Эрүүл мэндийн даатгал	7,754,799.24	9,243,247.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,308,474.55	45,114,900.00
210301	Гэрэл, цахилгаан	2,335,571.55	2,723,128.49
210302	Түлш, халаалт	12,857,000.00	41,209,369.51
210303	Цэвэр, бохир ус	115,903.00	1,182,402.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,052,166.19	24,639,023.00
210401	Бичиг хэрэг	1,996,000.00	3,013,950.00
210402	Тээвэр, шатахуун	12,191,309.00	17,466,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,667,057.19	1,278,773.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,147,800.00	2,880,300.00
2105	Нормативт зардал	16,176,492.00	10,601,897.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,449,992.00	6,368,897.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,726,500.00	4,233,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,959,050.00	11,667,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,482,250.00	6,945,000.00
210604	Урсгал засвар	3,476,800.00	4,722,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,955,450.00	15,134,450.00
210702	Дотоод албан томилолт	9,955,450.00	15,134,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,903,492.00	2,415,741.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,866,992.00	1,267,741.00
210803	Даатгалын үйлчилгээ	442,600.00	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.00	335,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210807	Газрын төлбөр	49,400.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	398,500.00	330,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,169,190.11	18,608,851.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,169,190.11	16,888,851.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,707,646.11	16,888,851.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,461,544.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,720,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,720,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	18,830,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	18,830,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	18,830,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	18,830,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	18,830,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(18,830,000.00)
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2013 оны 12-р сарын 31	281,217,975.40	32,432,859.50	295,166,916.57	608,817,751.47
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	281,217,975.40	32,432,859.50	295,166,916.57	608,817,751.47
4	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,857,306,841.43	4,857,306,841.43
5	2024 оны 12-р сарын 31	281,217,975.40	32,432,859.50	5,152,473,758.00	5,466,124,592.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
-----	----------	------------	-----------------------------	-----------------

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	756,323,700.00	738,774,653.39	17,549,046.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	756,323,700.00	738,774,653.39	17,549,046.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	746,992,800.00	738,774,653.39	8,218,146.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	539,048,200.00	538,327,229.66	720,970.34
210101	Үндсэн цалин	344,917,100.00	344,626,886.55	290,213.45
210102	Нэмэгдэл	130,891,100.00	130,966,458.93	(75,358.93)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,912,700.00	20,108,000.00	(195,300.00)
210104	Урамшуулал	43,327,300.00	42,625,884.18	701,415.82
2102	АО-с НД-д төлөх шимтгэл	78,636,500.00	72,044,412.73	6,592,087.27
210201	Тэтгэврийн даатгал	52,345,400.00	49,480,401.64	2,864,998.36
210202	Тэтгэмжийн даатгал	5,275,800.00	5,275,047.38	752.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,514,800.00	5,378,818.45	4,135,981.55
210204	Ажилгүйдлийн даатгал	948,700.00	2,666,897.51	(1,718,197.51)
210205	Эрүүл мэндийн даатгал	10,551,800.00	9,243,247.75	1,308,552.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,114,900.00	45,114,900.00	-
210301	Гэрэл, цахилгаан	4,900,000.00	2,723,128.49	2,176,871.51
210302	Түлш, халаалт	39,527,400.00	41,209,369.51	(1,681,969.51)
210303	Цэвэр, бохир ус	687,500.00	1,182,402.00	(494,902.00)
2104	Хангамж, бараа материал	24,788,000.00	24,639,023.00	148,977.00
210401	Бичиг хэрэг	2,466,600.00	3,013,950.00	(547,350.00)
210402	Тээвэр, шатахуун	18,204,000.00	17,466,000.00	738,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,232,400.00	1,278,773.00	(46,373.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225,200.00	0	225,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,659,800.00	2,880,300.00	(220,500.00)
2105	Нормативт зардал	18,612,000.00	18,600,897.00	11,103.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,374,700.00	14,367,897.00	6,803.00
210502	Хоол, хүнс	0	0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,237,300.00	4,233,000.00	4,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,534,700.00	22,498,000.00	36,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,804,700.00	17,776,000.00	28,700.00
210604	Урсгал засвар	4,730,000.00	4,722,000.00	8,000.00
2107	Томилолт, зочны зардал	15,167,600.00	15,134,450.00	33,150.00
210702	Дотоод албан томилолт	15,167,600.00	15,134,450.00	33,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,090,900.00	2,415,741.00	675,159.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,270,000.00	1,267,741.00	2,259.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,100.00	0	96,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	452,400.00	450,000.00	2,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	337,100.00	335,000.00	2,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	115,900.00	33,000.00	82,900.00
210807	Газрын төлбөр	48,500.00	0	48,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	770,900.00	330,000.00	440,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,330,900.00	0	9,330,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,330,900.00	0	9,330,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,330,900.00	0	9,330,900.00

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	756,323,700.00	755,663,504.39	660,195.61
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	756,323,700.00	755,663,504.39	660,195.61
310001	Улсын төсвөөс санхүүжих	756,323,700.00	755,663,504.39	660,195.61
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	43	43	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-
610001	Төсвийн байгууллага	1	1	-
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	-
620001	Удирдах ажилтан	1	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	-
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-
620004	Гэрээт ажилтан	0	0	-

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 94,403.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн байдлын тайланд авлагыг 238.8 мянган төгрөгөөр, аж ахуйн материалын зардлыг 2,050.1 мянган төгрөгөөр, өглөгийг 11,970.3 мянган төгрөгөөр тус тус дутуу,
- Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 22,082.0 мянган төгрөгөөр илүү,
- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 6,538.3 мянган төгрөгөөр дутуу, түлш халаалтын зардлыг 3,081.5 мянган төгрөгөөр, цэвэр бохир усны зардлыг 1,087.9 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 8,650.0 мянган төгрөгөөр, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 40.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 79.2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлын 16,888.8 мянган төгрөгөөр тус тус дутуу,
- Үр дүнгийн тайланд гэрэл цахилгааны зардлыг 1,087.9 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 40.0 мянган төгрөгөөр, бараа материал акталсны зардлыг 79.2 мянган төгрөгөөр тус тус илүү,
- Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд 1,720.0 мянган төгрөгийн орлого, төвлөрүүлэх шилжүүлгийг дансны код зөрүүлж тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зарлыг 6,369.0 мянган төгрөгөөр илүү, багаж, техник, хэрэгсэл худалдан авах зардлыг 6,369.0 мянган төгрөгөөр дутуу,
- Санхүүгийн тайланд 16,888.9 мянган төгрөгийн өглөгийг тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийж байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн боловч тооллогын материал дутуу, тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг дутуу хийсэн, тооцоо бодоогүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Санхүүгийн тайланд 1-с дээш жилийн насжилттай он дамнасан 30,473.5 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Он дамнасан авлагыг тооцоо нийлж барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 834,067.1 мянган төгрөгийн 51 мэдээллээс, цалингаас бусад 5 саяаас дээш орлогын гүйлгээний 758,043.7 мянган төгрөгийн 14, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 16,856.4 мянган төгрөгийн 7 мэдээллийг тус тус мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр";, 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг";, 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв

байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн байршуулаагүй мэдээллийг нөхөн мэдээлэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалинг нийгмийн даатгалд 740.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж илүү төлөлттэй гарсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 хуулийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх"; -тэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалинг нийгмийн даатгалд зөрүүгүй тайлагнах, авлагыг барагдуулах зөвлөмж хүргүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулаггүй		Тоо	Дүн
										Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв	Санхүүгийн байдлын тайланд авлагыг 238.8 мянган төгрөгөөр, аж ахуйн материалын зардлыг 2,050.1 мянган төгрөгөөр, өглөгийг 11,970.3 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	1	14,259.2	-	-	1	14,259.2	1	14,259.2	-	-	-	-
	Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 22,082.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	22,082.0	-	-	1	22,082.0	1	22,082.0	-	-	-	-
	Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 6,538.3 мянган төгрөгөөр дутуу, тулш халаалтын зардлыг 3,081.5 мянган төгрөгөөр, цэвэр бохир усны зардлыг 1,087.9 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 8,650.0 мянган төгрөгөөр, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 40.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 79.2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 16,888.8 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	1	31,877.5	-	-	1	31,877.5	1	31,877.5	-	-	-	-
	Үр дүнгийн тайланд гэрэл цахилгааны зардлыг 1,087.9 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 40.0 мянган төгрөгөөр, бараа материал акталсны зардлыг 79.2 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан.	1	1,207.1			1	1,207.1	1	1,207.1				

Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв	Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд 1,720.0 мянган төгрөгийн орлого, төвлөрүүлэх шилжүүлгийг дансны код зөрүүлж тайлагнасан.	1	1,720.0		1	1,720.0	1	1,720.0					
	Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зарлыг 6,369.0 мянган төгрөгөөр илүү, багаж, техник, хэрэгсэл худалдан авах зардлыг 6,369.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	6,369.0		1	6,369.0	1	6,369.0					
	Санхүүгийн тайланд 16,888.9 мянган төгрөгийн өглөгийг тусгаагүй.	1	16,888.9		1	16,888.9	1	16,888.9					
Дүн		7	94,403.7	-	7	94,403.7	7	94,403.7	-	-	-	-	

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
	Ажиллагсдын амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 106.7 мянган төгрөгийг илүү олгожээ.	1	106.70	1	106.70	-	-	-	-	-	-		
	"Ажилтанд ажил хавсран ажилласны нэмэгдэл 360.0 мянган төгрөгийг шийдвэргүйгээр олгосон.	1	360.00	1	360.00	-	-	-	-	-	-		
	Батлагдсан бүтэц, орон тоонд сумд ажиллах голомтын эмчийг батлаагүй байхад 4,468.4 мянган төгрөгийн хавсран ажилласны нэмэгдлийг үндэслэлгүйгээр олгосон	1	4,468.40	-	-	1	4,468.40	-	-	-	-		
	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 7,999.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.	1	7,999.00	-	-	1	7,999.00	-	-	-	-		
	Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн боловч тооллогын материал дутуу, тооцоо бодоогүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-		
	Санхүүгийн тайланд 1-с дээш жилийн насжилттай он дамнасан 30,473.5 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага бүртгэлтэй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-		
	Цалинг нийгмийн даатгалд 740.1 мянган төгрөгөөр зөрүлтэй тайлагнаж илүү төлөлттэй гарсан.	1	740.1										
	Дүн	7	13,674.20	2	466.70	4	12,467.40	1	-	-	-		

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга		Нийт алдаа, зөрчлийн дүн														
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		Үүнээс:						
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12						
Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 834,067.1 мянган төгрөгийн 51 мэдээллээс, цалингаас бусад 5 саяаас дээш орлогын гүйлгээний 758,043.7 мянган төгрөгийн 14, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 16,856.4 мянган төгрөгийн 7 мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.	1	-	1	-	-	-	1	-	-	-	1	-	-	-	-	-
Нийт		1	-	1	-	-	-	1	-	-	-	1	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах		Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		Өөрчлөлтгүй		Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
		Аудитад хамрагдсан	Түүвэрт хамруулсан	Аудит хийээгүй	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	1	1	1	1	1	1
НИЙТ		2	3	4	5	7	8	9	10

